

**ЦАХИЛГААН ТЕХНИКИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДУНД ХУГАЦААНЫ
СТРАТЕГИ**

(2017-2020 он)

Улаанбаатар

2017 он

1

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СТРАТЕГИЙН ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

- 1.1 Үндэслэл
- 1.2. Стратеги төлөвлөгөөний хамрах хүрээ, хугацаа, үе шат
- 1.3. Стратеги төлөвлөгөөг боловсруулсан арга зүй, үндсэн зарчим, зохион байгуулалт

ХОЕРДУГААР БҮЛЭГ. ЦАХИЛГААН ТЕХНИКИЙН СТАНДАРТЧИЛАЛ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

- 1.1 Цахилгаан техникийн стандартчиллын эрх зүйн орчин
- 1.2 Цахилгаан техникийн стандартчиллын өнөөгийн байдал
- 2.3 Цахилгаан техникийн тохирлын үнэлгээний өнөөгийн байдал
- 2.4 Цахилгаан техникийн үндэсний хорооны гадаад, дотоод орчны шинжилгээ

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЦАХИЛГААН ТЕХНИКИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ

- 3.1 Цахилгаан техникийн үндэсний хорооны алсын хараа, эрхэм зорилго, баримтлах зарчим
- 3.2 Стратегийн зорилго, зорилт болон үйл ажиллагааны хамрах хүрээ
- 3.3. Үйл ажиллагааны зорилт

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

- 4.1. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, бүтэц, зохион байгуулалт
- 4.2. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх орчин
- 4.3. Стратегийн хяналт-шинжилгээ үнэлгээ
- 4.4. Стратеги төлөвлөгөөнд тодотгол хийх

ХАВСРАЛТ:

1-р хавсралт. Дунд хугацааны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө */1-р сард болсон NEC-ийн хурал дээр танилцуулагдсан/*

2-р хавсралт. Эрчим хүч, Сэргээгдэх эрчим хүчний стандартчиллын техникийн хороодын 2017-2020 онуудын хөтөлбөрүүд */СТЗГ-ын даргын тушаалаар батлагдсан/*

3-р хавсралт. Мэдээлэл, холбооны технологи, Хэмжил зүй, Ахуйн цахилгаан хэрэгслийн техникийн хороодын IEC стандартыг боловсруулах 2017-2020 онуудын хөтөлбөрүүд */СТЗГ-ын даргын тушаалаар батлагдсан хөтөлбөрийн холбогдох хэсэг/*

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СТРАТЕГИЙН ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

1.1. Үндэслэл

Олон Улсын Цахилгаан Техникийн Комисс (IEC буюу цаашид ОУЦТК гэх) нь эрчим хүч болон электроникийн бүтээгдэхүүн, систем болон үйлчилгээ зэрэг электротехнологид хамаарах, зөвшилцөлд суурилсан олон улсын IEC стандартыг боловсруулж, тохирлын үнэлгээний тогтолцоог бий болгож зохицуулдаг 83 Гишүүн, 84 Түншлэгч гишүүн орнуудыг хамарсан олон улсын байгууллага юм.

Стандартчилал, техникийн зохицуулалтын эрх зүйн шинэчлэлийн энэ үед Монгол Улсын дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөлттэй уялдуулан цахилгаан техникийн салбарын стандартчиллыг боловсронгуй болгон хөгжүүлэх, тохирлын үнэлгээний тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн бий болгох нь зүйтэй юм.

Тайлбар: “Цахилгаан техник гэдэг нь цахилгаан, соронзон, цахилгаан-соронзон үзэгдлийг практикт хэрэглэх технологи” гэж ОУЦТК-ийн нэр томъёоны санд тайлбарласан байна.

Энэхүү дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа доор дурдсан баримт бичгүүдийг судалж, нийцүүлэв. Үүнд:

- ДХБ-ын Худалдаан дах техникийн саад тотгорын тухай хэлэлцээр
- Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль
- Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого
- Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030,
- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 2016-2020 он
- Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого
- Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого
- Үндэсний чанарын хөтөлбөр, Засгийн газрын 2016 оны 344 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

Цахилгаан техникт хамаарах салбаруудын стандартчилал, тохирлын үнэлгээний үйл ажиллагааны харилцан уялдааг хангах, үндэсний түвшинд нэгтгэн зохион байгуулах зорилгоор энэхүү стратегийг боловсрууллаа.

Төслийг боловсруулах явцад Цахилгаан техникийн үндэсний хорооны гишүүд, Германы Физик техникийн хүрээлэн, Германы Цахилгаан техникийн хүрээлэнгийн экспертүүдийн саналыг тусгав.

1.2. Стратеги төлөвлөгөөний хамрах хүрээ, хугацаа, үе шат

Энэхүү стратеги төлөвлөгөө нь цахилгаан техникийн салбарын стандартчилал, тохирлын үнэлгээнд оролцогч талууд, үндэсний стандартчиллын тусгал хороодыг хамрах бөгөөд 2 үе шаттай, 2017-2020, 2021-2023 онуудад хэрэгжинэ.


1.3. Стратеги төлөвлөгөөг боловсруулсан арга зүй, үндсэн зарчим, зохион байгуулалт

Эрх зүйн баримт бичиг, цахилгаан техникийн стандартчилал, тохирлын үнэлгээний өнөөгийн төлөв байдал → орчны шинжилгээ → алсын хараа → эрхэм зорилго → стратегийн зорилтууд → үйл ажиллагааны зорилтууд → хэрэгжүүлэх арга зам → гарах үр дүн → хяналт, үнэлгээ гэсэн арга зүйн дарааллын дагуу гүйцэтгэлээ.

Үндсэн зарчим: Цахилгаан техникийн үндэсний хорооны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад дараах зарчмуудыг баримталсан болно. Үүнд:

- Стратеги төлөвлөгөө боловсруулах онол, арга зүйг баримтлах
- Батлагдсан эрх зүйн баримт бичиг, бодлого, хөтөлбөртэй нийцүүлэх
- Улс орны нийгэм, эдийн засаг, стандартчилал, хэмжил зүйн хөгжлийн чиг хандлагыг харгалзах

Энэхүү баримт бичиг нь Цахилгаан техникийн стандартчилал, тохирлын үнэлгээний талаар Цахилгаан техникийн үндэсний хорооноос баримтлах үндсэн стратеги бөгөөд эрчим хүч, цахилгаан техник, мэдээлэл, харилцаа холбоо, хэмжил зүй зэрэг салбарын бодлоготой харилцан уялдаатай хэрэгжүүлнэ.



1-р зураг. Стратеги төлөвлөгөөний арга зүйн дараалал

ХОЕРДУГААР БҮЛЭГ. ЦАХИЛГААН ТЕХНИКИЙН СТАНДАРТЧИЛАЛ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1 Стандартчилал, тохирлын үнэлгээний эрх зүйн орчин

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлснээс хойш арав гаруй жил, стандартчилал, хэмжил зүйн байгууллага олон улсын стандартчиллын байгууллагад гишүүнчлэлээр элсэн орсноор гучаад жил, Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элсч, гишүүн орнуудын хүрээнд мөрдөгдөж буй худалдааны хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч, нэгдэн орж ажилласнаар арав гаруй жил болжээ.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг улс орны нийгэм, эдийн засгийн харилцааны өөрчлөлт, шинэчлэлтэй уялдуулан сайжруулах, түүнчлэн Монгол Улс Дэлхийн худалдааны болон олон улсын, бүс нутгийн стандартчиллын байгууллагын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний чанар, аюулгүйн шаардлагыг стандартаар тогтоох, түүнийг үнэлэх, хүлээн зөвшөөрч баталгаажуулах харилцааг зохицуулж байгаа эрх зүйн орчноо олон улсын нийтлэг жишиг, зарчимд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай болсон тул уг хуулийг шинэчлэн боловсруулаад байна.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагыг үндэслэн Стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, дараах зарчмын асуудлыг хуулийн төсөлд тусгасан:

1. Монгол Улсад мөрдөх стандарт, техникийн баримт бичгийг зөвлөмжийн хэлбэрээр, сонгон хэрэглэх, тэдгээрийг боловсруулах, хүлээн зөвшөөрч батлах бүхий л үйл явцад нээлттэй, ил тод оролцооны тэгш байдлыг хангах, улмаар үйлдвэрлэл, худалдаа, тохирлын үнэлгээний хүрээнд түүнийг иш татах;

2. Үндэсний аюулгүй байдлын шаардлагууд, залилах практикаас урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал амьтан, ургамлын амьдрал, эсхүл эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах зорилгоор техникийн зохицуулалтыг боловсруулан мөрдөх;

3. үйлдвэрлэл, бараа бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн, стандартчилал, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн үйл ажиллагааны хамрах хүрээ, ажиллах зарчим, бүтэц, зохион байгуулалт, эрх үүргийг нарийвчлан тогтоох, улмаар үйлдвэрлэл, худалдаанд байгаа техникийн элдэв саад тотгор, хүндрэлийг багасгах замаар олон улсын гэрээ, хэлэлцээрийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх боломж, орчныг бүрдүүлэх;

4. хуулийн нэр томъёог уг хуулийн төслийн агуулга, олон улсад нийтээр даган мөрдөж буй аргачлал, арга зүйн удирдамж, зааварт нийцүүлэх.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар дараах ач холбогдолтой:

-стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэл, тохирлын үнэлгээний үйл ажиллагаа олон улсын нийтлэг жишгийн дагуу явагдах эрх зүйн орчин, нөхцөл бүрдэнэ;

-техникийн зохицуулалтаар бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аюулгүйн үзүүлэлт, шаардлагыг хуульчлан тогтоосноор нийтийн ашиг сонирхол, хүрээлэн буй орчин, улс орны аюулгүй байдал хангагдаж, улмаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлага дээшилж, идэвх санаачлага нэмэгдэнэ;

-тохирлын үнэлгээний байгууллагуудад тавигдах шаардлага, зохицуулалт тодорхой болж, үйлдвэрлэл, худалдаан дахь техникийн саад тотгор, хүндрэл, бэрхшээл багасна;

-стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны хамрах хүрээ, эрх үүрэг тодорхой болж, тус байгууллагын хөрөнгө, санхүүгийн чадамж болон үйл ажиллагааны үр дүн дээшилнэ;

-олон улс, бүс нутаг гадаад орны дэвшилтэт стандартыг MNS ISO GUIDE 21-1:2007 “Олон улсын стандарт болон олон улсын бусад баримт бичгийг бүс нутаг буюу үндэсний хэмжээнд авч хэрэглэх нь-1-р хэсэг : Олон улсын стандартыг хэрэглэх нь”, MNS ISO GUIDE 21-2:2007 Олон улсын стандарт болон олон улсын бусад баримт бичгийг бүс нутаг буюу үндэсний хэмжээнд авч хэрэглэх нь-2-р хэсэг : Олон улсын стандартаас бусад олон улсын баримт бичгийг хэрэглэх нь” арга зүйн баримт бичгийн дагуу хэрэглэснээр үндэсний үйлдвэрлэл эрхлэгчид өөрийн бараа бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээл дээр гаргах, шинэ технологи эзэмших өргөн боломж, нөхцөл бүрдэж, улмаар тэдгээрийн өрсөлдөх чадвар дээшилж, улсын эдийн засгийн тогтвортой өсөлтөд эергээр нөлөөлнө.

2.2 Цахилгаан техникийн стандартчиллын өнөөгийн байдал

Монгол улс 1979 онд Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүнээр элссэн юм. Түүнчлэн Монгол улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад элссэнээр СХЗГ “Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай” хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн.

Уг хэлэлцээрийн дагуу дараах үүргүүдийг хүлээсэн: Үүнд:

- үндэсний стандарт боловсруулахад олон улсын стандартыг суурь болгох
- стандартыг зөвлөмжийн шинжтэй хэрэглэх
- үндэсний аюулгүй байдлыг хангах, хуурамч бүтээндхүүнээс сэргийлэх, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, амьтан, ургамал, байгаль орчныг хамгаалах зорилгоор заавал мөрдөх шинжтэй техникийн зохицуулалтыг батлан хэрэгжүүлэх

Олон улсын цахилгаан техникийн комисс нь эрчим хүч болон электроникийн бүтээгдэхүүн, систем болон үйлчилгээ зэрэг электротехнологид хамаарах, зөвшилцөлд суурилсан олон улсын IEC стандартыг боловсруулж, тохирлын үнэлгээний тогтолцоог би удирддаг 83 Гишүүн, 84 Түншлэгч гишүүн орнуудыг

хамарсан олон улсын байгууллага юм. Монгол Улс 2001 онд тус ОУЦТК-ийн “Хөгжиж буй орнуудад зориулсан хөтөлбөр”-т хамрагдан, өнөөдрийн байдлаар 91 стандартыг үндэсний стандартаар батлаад байна. 2014 оны 11 дүгээр сард ОУЦТК-ийн төлөөлөгчид манай оронд ирж, цахилгаан техникийн стандартчиллын талаар уулзалт семинар зохион байгуулсан юм. Тус семинараас гаргасан зөвлөмжийн дагуу Монгол Улсын Шадар сайдын 2014 оны 93 дугаар тушаалаар үндэсний түвшинд цахилгаан, электрон техникийн салбарын стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, зохицуулалтын уялдааг хангах үүрэг бүхий “Цахилгаан техникийн үндэсний хороо”-ны бүрэлдэхүүнийг баталсан. Уг хороонд үйлдвэрлэгч, төрийн ба шинжлэх ухааны байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөл орсон болно. Монгол улстай “Түншлэгч Нэмэх буюу Affiliate Plus” статустайгаар хамтран ажиллах болсон тухайгаа ОУЦТК-ийн Ерөнхий нарийн бичгийн даргаас 2015-01-14-нд Стандартчилал, хэмжил зүйн газрын даргад ирүүлсэн захидалдаа мэдээлсэн. Ингэснээр ОУЦТК-ийн 400 гаруй стандартыг Монгол улсад нутагшуулах эрх нээгдснээс одоогоор 280 гаруй стандартыг хүлээн аваад байна.

Түүнчлэн Стандартчилал, хэмжилзүйн газрын дэргэдэх Эрчим хүч, Цахилгаан техник, Харилцаа холбоо зэрэг салбарын стандартчиллын техникийн хороод уг олон улсын байгууллагын “Тусгал техникийн хороод” болж зохион байгуулагдсан.


Цахилгаан техникийн стандартчиллын үйл ажиллагааг олон улсын жишгийн дагуу оновчтой зохион байгуулахын тулд “Түншлэгч оронд Цахилгаан техникийн үндэсний хороо байгуулах удирдамж” баримт бичгийг MNS 6640:2016 үндэсний стандартаар баталсан. Монгол улсын Шадар сайдын тушаалаар Цахилгаан техникийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 2017 оны 1 дүгээр сард шинэчлэн батлаад байна. Тус хороо нь эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулах, түгээх ажиллагаа эрхлэгч болон бодлого боловсруулагч, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөллөөс бүрдэж байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Германы Физик техникийн хүрээлэнгээс хэрэгжүүлж буй “Эрчим хүчний салбарт чанарын дэд бүтцийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн хүрээнд Цахилгаан техникийн үндэсний хороог бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцоод байна.


“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” хуулийн дагуу стандартыг эрх зүйн сонгон хэрэглэх ба заавал мөрдөх хэм хэмжээтэй баталж байна. Стандарт боловсруулах ажлыг Стандартчиллын төв байгууллагын дэргэдэх 55 техникийн хороодын хэрэгжүүлдэг. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 6176 стандарт мөрдөж байна. Эдгээрээс цахилгаан техникийн салбарт хамаарах 629 стандарт нийт стандартын 10.1 %, үүнд IEC стандарт 99 буюу 15,7 %-ийг эзэлж байгаа нь тун хангалтгүй юм.

	Цахилгаан техникийн салбарт хамаарах үндэсний стандартчиллын салбар	Нийт станда ртын тоо	Guide 21-ийн дагуу баталсан стандартын тоо	Үүнд ОУЦТК-ийн стандартын тоо
1.	01.080, 01.100 График тэмдэг, техникийн зураг,	148	81	8
2.	17.220 Цахилгаан ба соронзон хэмжилт	53	16	13
3.	19 Сорилт	51	38	7
4.	27 Эрчим хүч ба дулаан дамжуулах техник	62	19	3
5.	29 Цахилгаан техник	44	25	24
6.	33 Цахилгаан холбоо, дуу, дүрсийн техник	101	8	7
7.	35 Мэдээллийн технологи, оффисын машин техник /ISO/IEC/	83	51	30
8.	97 Ахуйн ба худалдааны тоног төхөөрөмж	87	42	36
9.	Дүн	629	280	128


1-р хүснэгт. Цахилгаан техникт хамаарах нийт стандарт болон IEC стандартын тоо /стандартын салбарын ангилалтаар/




2-р зураг. Монгол улсын стандарт ба цахилгаан техникийн салбар, IEC стандартын тоо



3-р зураг. Монгол улсад мөрдөж буй цахилгаан техникийн салбарын стандартын тоо /салбарын ангилалтаар/



4-р зураг. Монгол улсад мөрдөж буй цахилгаан техникийн салбарын стандартыг дахин хянах хэрэгцээ шаардлага /салбарын ангилалтаар/




5-р зураг. Цахилгаан техникийн салбарт мөрдөж буй IEC стандартыг баталсан байдал /оноор/

4 ба 5-р зургуудаас харахад цахилгаан техникийн стандартыг 2001-2005 оноос үндэсний стандартаар баталж эхэлсэн бөгөөд 2006-2010 оны үед энэ ажил зогсонги болсон байна. Үндэсний стандартаар батлагдсан стандартад олон улсын түвшинд орж орж буй өөрчлөлт, нэмэлт, хүчинтэй эсэхийг мөшгөж, стандартчиллын хөтөлбөрт тусган, шинэчлэх ажил огт хийгдээгүйгээс одоо мөрдөж буй MNS IEC стандартын 18.6 %-ийг хүчингүйд тооцох, 66,2 % нь нэмэлт өөрчлөлт оруулах, зөвхөн 15,2 %-ийг хэвээр мөрдөх боломжтой байна.

2.3 Цахилгаан техникийн тохирлын үнэлгээний өнөөгийн байдал

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” хуулийн дагуу Тохирлын үнэлгээг бүтээгдэхүүнд хэрэглэгчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, зөв сонголт хийхэд туслах, хуурамч бүтээгдэхүүнээс хэрэглэгчийг хамгаалах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор хэрэглэдэг. Үүнд нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг тохирлын баталгаанд заавал хамруулдаг. Засгийн газрын 127 дугаар тогтоолоор “Тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-ыг баталсан. Уг жагсаалтад зарим төрлийн цахилгаан техникийн бүтээгдэхүүн, үйлчилгээ орсон хэдий ч тохирлын батлагаагүйгээр зах зээлд нийлүүлэгдэж байна. Цахилгаан техникийн тохирлын үнэлгээний тогтолцоо одоогоор бий болоогүй байна. Энэхүү чиглэлд үндэсний мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх зорилгоор 20 хүнийг IEC ACAS цахим сургалтад бүртгүүлээд байна.

2.4 Цахилгаан техникийн үндэсний хорооны гадаад, дотоод орчны шинжилгээ



1-р зураг. Цахилгаан техникийн үндэсний хорооны гадаад ба дотоод орчин

Цахилгаан техникийн үндэсний хорооны үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны зүгээс нөлөөлөх хүчин зүйлийг дор дурдсан байдлаар тодорхойлж байна.

Гадаад орчны нөлөөлөл:	Дотоод орчны нөлөөлөл
<p>Эдийн засгийн орчин:</p> <ul style="list-style-type: none"> - Нарийн бичгийн даргын газрын төсөв - Олон улсаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэмжээ - Бусад санхүүжилт <p>Улс төрийн орчин:</p> <ul style="list-style-type: none"> - Сонгуулийн үр дүн - Засгийн газрын харъяа байгууллагын бүтэц, өөрчлөлт <p>Эрх зүйн орчин:</p> <ul style="list-style-type: none"> - Хууль, тогтоомж - Бодлого, хөтөлбөр <p>Хэрэглэгч:</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж - Иргэд <p>Түншлэгч:</p> <ul style="list-style-type: none"> - Олон улсын цахилгаан техникийн комисс (IEC) - Германы цахилгаан техникийн байгууллага (DKE) - Германы физик техникийн хүрээлэн (PTB) - Шадар сайдын ажлын алба - СХЗГ /нарийн бичгийн даргын газар/ - Эрчим хүч, уул уурхай, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн яам, агентлагууд - Мэргэжлийн холбоод - Тусгал техникийн хороод - Сургалт, судалгаа шинжилгээний байгууллагууд - Бизнес эрхлэгчид - Шинээр бий болох баталгаажуулалтын байгууллагууд 	<p>Зорилго, стратеги:</p> <ul style="list-style-type: none"> - Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл - Эрхэм зорилго, үнэт зүйлс, эрхэмлэх зарчим - Стратеги, зорилт, үйл ажиллагаа - Стандартчиллын тэргүүлэх чиглэл - Стандартчиллын хөтөлбөр <p>Бүтэц, зохион байгуулалт:</p> <ul style="list-style-type: none"> - Нарийн бичгийн даргын газрын бүтэц, зохион байгуулалт - Ажлын байрны хуваарилалт - Ажлын байрны тодорхойлолт <p>Дотоод дүрэм, журам:</p> <ul style="list-style-type: none"> - Хорооны журам - Хорооны гишүүд, олон нийттэй харилцах суваг <p>Хүний нөөц:</p> <ul style="list-style-type: none"> - Гишүүдийн мэргэжил, боловсрол, мэдлэг, ур чадвар, хандлага - Мэдээлэл, сургалт - Гишүүдийн идэвх, оролцоо <p>Ажлын байрны нөхцөл:</p> <ul style="list-style-type: none"> - Нарийн бичгийн даргын газрын байршил <p>Санхүү:</p> <ul style="list-style-type: none"> - Хорооны санхүүгийн чадавх - Орлогын эх үүсвэр - Орлогын захиран зарцуулалт <p>Цахилгаан техникийн салбарт батлагдсан IEC стандарт:</p> <ul style="list-style-type: none"> - тоо - хүчин төгөлдөр байдал

2.4.1 Гадаад орчин:

- 1) Эрх зүйн орчин
 - Хууль, эрх зүйн орчинг бий болгох
- 2) Санхүү
 - Хорооны санхүүгийн чадавхийг сайжруулах бүхий л бололцоог эрэлхийх
 - Нарийн бичгийн даргын газрын санхүүжилтыг тусгах
 - Цахилгаан техник хамаарах салбарын стандарт боловсруулах санг улсын төсөв, олон улсаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, сонирхогч талуудын санхүүжилтээр бий болгох

- ЦТҮХ-ны гишүүнчлэлийн хураамжийг бий болгох
- 3) Оролцогч талууд
 - Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, түншлэгч нарын хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх бодлогыг баримтлах.
 - Үндэсний тогтвортой хөгжлийг хангах зорилгоор олон улсын стандартыг боловсруулахад Тусгал хороодын үүрэг ролийг нэмэгдүүлэх
 - Олон улсын стандартыг үндэсний стандартаар батлах үйл явцыг хялбарчлах

2.4.2 Дотоод орчин:

- 1) Нарийн бичгийн даргын газар
 - ЦТҮХ-ны алсын хараа, эрхэм зорилгодоо гишүүдийг нэгтгэж үнэт зүйлс, баримтлах зарчмаа эрхэмлэн дээдлэх
 - Нарийн бичгийн даргын газрын орон тоог бий болгох
 - Хүний нөөцийг чадваржуулах, сургалт, хөгжлийг эрхэмлэх
 - Хорооны бүтэц, зохион байгуулалтыг аль болох оновчтой, боловсронгуй болгох
 - Хорооны дүрмийг боловсруулан, нөхцөл байдалд нийцүүлэн боловсронгуй болгох,
 - Үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээний үр нөлөөг дээшлүүлэх, шинэ мэдлэг, санал, санаачилгыг дэмжих
 - Нарийн бичгийн даргын газрын ажлын байрны нөхцөл, эрүүл ахуйг дотоод нөөц боломждоо тулгуурлан сайжруулах
 - Хорооны санхүүгийн чадавхыг сайжруулах, шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг байнга эрэлхийлэх, зориулалтын дагуу, хэмнэлттэй, үр дүнтэй захиран зарцуулах, илт тод байдлыг хангах
 - Үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтэд тасралтгүй сурталчлан таниулах, мэдээллийг ил тод нээлттэй байлгах
- 2) Оролцогч тал
 - Оролцогч талуудын сонирхолд нийцсэн стандартыг боловсруулах, үйл ажиллагааны уялдааг сайжруулах,
 - Оролцогч талуудын мэдээллээр хангах
 - Сахилга хариуцлагыг дээшлүүлэх бодлого баримтлана.

Цахилгаан техникийн үндэсний хорооны SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<p>IEC Affiliate Plus статустай мэдээлэл, арга зүйгээр хангагддаг.</p> <p>Нийт 400 стандарт үнэгүй авах эрхтэй</p> <p>Тохирлын үнэлгээний он-лайн сургалтад үндэсний мэргэжилтнуудийг үнэ төлбөргүй сургах Туршлагатай Ментор байгууллагатай.</p> <p>РТВ төслийн зүгээс Хороог бэхжүүлэх тал дээр хамтран ажиллах төлөвлөгөөтэй.</p> <p>Эрчим хүч, мэдээлэл холбооны салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичиг боловсруулагдсан.</p> <p>Хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулсан.</p> <p>Хорооны дарга, нарийн бичгийн дарга нь стандартчилал, тохирлын үнэлгээний ажлын туршлагатай</p> <p>Хорооны дарга, нарийн бичгийн дарга тогтмол цалин, байршилтай</p>	<p>Үйл ажиллагааг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр байхгүй.</p> <p>ЦТҮХ нь хүний нөөц болон санхүүгийн хувьд бэхжээгүй.</p> <p>Нарийн бичгийн дарга нь үндсэн ажлын хажуугаар хавсран гүйцэтгэдэг.</p> <p>Хорооны гишүүдийн ажил үүргийн хуваарь, үүрэг хариуцлага тодорхой бус</p> <p>Батлагдсан MNS стандартуудыг шинэчлэх шаардлагатай</p> <p>Олон улсын стандартчиллын техник ажлын туршлага байхгүй</p> <p>Стандартчилалд талуудын оролцоо сул</p> <p>Тохирлын үнэлгээний тогтолцоо, хүний нөөц бүрдээгүй</p> <p>Хувийн хэвшлийн оролцоо сул</p>
Боломж	Бэрхшээл
<p>Шинээр боловсруулж буй стратеги төлөвлөгөөнд ДКЕ, РТВ байгууллагуудаас арга зүйн дэмжлэг авах боломжтой</p> <p>Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцад Нарийн бичгийн даргын газрын санхүүжилтыг тусгах</p> <p>Стандарт боловсруулах санг улсын төсөв, олон улсаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, сонирхогч талуудын санхүүжилтээр бий болгох</p> <p>ЦТҮХ-ны гишүүнчлэлийн хураамжийг бий болгох</p> <p>Олон улсын стандартчилалд Тусгал хороодын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх</p> <p>Олон улсын стандартыг батлах үйл явцыг хялбарчлах эрх зүйн орчныг бүрдүүлэх</p>	<p>Хорооны гишүүд нь ихэвчлэн улс төрөөс хамаарал бүхий төрийн байгууллагыг төлөөлдөг</p> <p>Олон улсын стандартчиллын 3 хэл нь төрийн үндсэн хэл нь биш</p> <p>Стандартыг орчуулж, баталдаг тул орчуулгын ажил хийх хүний болон санхүүгийн нөөц байхгүй.</p>

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЦАХИЛГААН ТЕХНИКИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ

3.1 Цахилгаан техникийн үндэсний хорооны алсын хараа, эрхэм зорилго, баримтлах зарчим

Алсын хараа

Бид цахилгаан техникийн стандартчиллыг олон улсын жишигт хүргэж, үндэсний тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулна.

Эрхэм зорилго

Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах, цахилгаан техникийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг хангахад стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого, үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлнэ.

Баримтлах зарчим

- Цахилгаан техникийн салбарын үндэсний стандартыг олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартад нийцүүлэх
- Стандартчилалд оролцогч талуудыг татан оролцуулах
- экспорт, инновацийн бүтээгдэхүүнийг зах зээлд гарахад нь дэмжлэг үзүүлэх
- тохирлын үнэлгээний тогтолцоог бий болгох замаар худалдааг хөнгөвчлөх
- техникийн зохицуулалтыг стандартчиллын үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх

2.2 Стратегийн зорилго, зорилт болон үйл ажиллагааны хамрах хүрээ

Цахилгаан техникийн стандартчиллын тэргүүлэх чиглэл

- Сэргээгдэх эрчим хүч
- Эрчим хүчний хэмнэлт, үр ашиг
- Эрчим хүчний чанар
- Ухаалаг сүлжээ ба хэмжилт
- Цахилгаан техникийн салбарын бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний аюулгүй байдал

3.3. Үйл ажиллагааны зорилт

3.3.1 Цахилгаан техникийн үндэсний хороог бэхжүүлнэ.

3.3.1.1 Олон улсын цахилгаан техникийн хорооны арга зүйн баримт бичиг болон стандартчилал, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалтын орчинд нийцүүлэн эрх зүйн бий болгоно.

3.3.1.2 Стандартчиллын үйл ажиллагаанд оролцогч талуудыг татан оролцуулах нөхцлийг бүрдүүлэх бодлого баримтална.

3.3.1.3 Цахилгаан техникийн үндэсний хороог санхүүгийн хувьд бэхжүүлнэ.

3.3.1.4 Хүний нөөцийг бэхжүүлж, орчин нөхцлийг сайжруулна.

- ЦТҮХ, тусгал техникийн хороодын гишүүдийг чадавхижуулах
- ЦТҮХ-ны гишүүдийг олон улсын стандартчиллын техник ажилд сургах

3.3.2 Цахилгаан техникийн стандартчиллын ажиллагааг олон улсын жишгийн дагуу зохион байгуулна.

Цахилгаан техникийн стандартчиллыг олон улсын жишгийн дагуу зохион байгуулахын тулд үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Цахилгаан техникийн салбарын талаах төрөөс баримталж буй бодлого, зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ОУЦТК-ийн Тусгал хороодыг байгуулан, ажиллуулна.
 - TC 1 Terminology
 - 1) TC 4 Hydraulic turbines
 - 2) TC 8 Systems aspects for electrical energy supply
 - 3) TC 13 Electrical energy measurement and tariff control
 - 4) TC 22 Power electronic systems and equipment
 - 5) TC 57 Power systems management and associated information exchange
 - 6) TC 61 Safety of household and similar electrical appliances
 - 7) SC 62A Common aspects of electrical equipment used in medical practice
 - 8) SC 65 B Measurement and control devices
 - 9) TC 85 Measuring equipment for electrical and electromagnetic quantities
 - 10) TC 104 Environmental conditions, classification and methods of test
- Зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, ОУЦТК-аас Түншлэгч гишүүн хөтөлбөрийн хүрээнд хүлээн авсан олон улсын стандартыг нутагшуулах бодлого баримтална.
- Цахилгаан техникийн бүтээгдэхүүн, үйлчилгээний стандартад олон улсын стандартын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.
- Цахилгаан техникийн стандартыг батлах үйл ажиллагааны загварыг шинэчлэн бий болгоно.
- Цахилгаан техникийн стандартыг олон улсын хэл дээр шууд авч хэрэглэх эрх зүйн орчныг бий болгоно.
- Цахилгаан техникийн нэр томъёоны нээлттэй өгөгдлийн сан бий болгох бодлого баримтална.

3.3.3 Цахилгаан техникийн салбарт аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадвар, үр ашгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

- Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах зэрэг зорилгоор техникийн зохицуулалтуудыг боловсруулахад мэдээлэл, арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах зэргээр мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллана.

- Цахилгаан техникийн салбарт менежментийн тогтолцоог хэрэгжүүлэхэд байгууллага аж ахуйн нэгжүүдийг дэмжин ажиллана.

3.3.4 Олон нийт, оролцогч талуудын мэдлэг ойлголт, оролцоог дээшлүүлэхэд хамтран ажиллана.

- Цахилгаан техникийн үндэсний хорооны үйл ажиллагааны тулах цэг нь нь оролцогч талууд юм.

- Цахилгаан техникийн чиглэлээр их дээд болон мэргэжлийн сургуульд суралцагсдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, стандартчилал, тохирлын үнэлгээний мэдлэг ойлголтыг төлөвшүүлэхэд ажлаа чиглүүлнэ.

- Цахилгаан техникийн чиглэлийн боловсон хүчин бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоонд стандартчиллын хичээлийг оруулна.

- Цахилгаан техникийн үндэсний хорооны гишүүд, Тусгал хороодын гишүүд, стандарт боловсруулагчид, бусад оролцогч талуудыг мэдээлэл, арга зүйгээр хангана.

- Стандартчиллын үйл ажиллагаанд оролцогч талууд, түншлэгчидтэй идэвхитэй хамтран ажиллана.

3.3.5 Цахилгаан техникийн тохирлын үнэлгээний тогтолцоог олон улсын жишгийн дагуу бүрэлдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

- Тохирлын үнэлгээний чиглэлээр үндэсний боловсон хүчнийг мэдээллээр хангана.

- Түншлэгч байгууллагатай хамтран тохирлын үнэлгээний сургалтыг зохион байгуулна.

- Худалдаан дах техникийн саад тотгорыг багасгах зорилгоор IEC EE, IEC Ex, IEC Q зэрэг тохирлын үнэлгээний тогтолцооны гэрчилгээг хэрэглэхэд мэдлэг, үйл ажиллагааг дэмжинэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

4.1. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, бүтэц, зохион байгуулалт

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлагын чиг үүргийг Цахилгаан техникийн үндэсний хорооны дарга хариуцаж, гишүүн байгууллагууд, оролцогч талуудад зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээг стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого хариуцсан Засгийн газрын гишүүнд танилцуулан хуваарилж, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөөнд нь тусгуулна.

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, биелэлтийг гаргах, тайлагнах асуудлыг Нарийн бичгийн даргын газар хариуцан, зохион байгуулна.

Стратеги төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Ажил үүргийг оновчтой хуваарилах:

-Гол ажлуудыг мэргэжлийн байгууллага, чадварлаг, туршлагатай ажилтанд хариуцуулах, шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг байгуулах

-Зайлшгүй шаардлагатай ур чадвар, удирдах чадвар, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, хэрэгжүүлэх дараалал, ач холбогдлыг эрэмблэх

-Стратегийг хэрэгжүүлэхэд Нарийн бичгийн даргын газарт шаардлагатай зохион байгуулалтыг хийх /дутагдаж байгаа шаардлагатай орон тоо, ажлын байр бий болгох, ажил үүргийн хуваарилалтыг дахин хийх, ажилтнуудыг сургалтад хамруулах, дүрэм журам шинэчлэх, шинээр боловсруулах гэх мэт/ хийх

2. Төсөв, зардал бүрдүүлэх, төлөвлөх, хуваарилах:

Төсвийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

- Төсвийн төлөвлөлтөөс
- Олон улсын төсөл хөтөлбөрөөс
- Засгийн газрын захиалгат ажил үйлчилгээний санхүүжилтээс
- Гишүүнчлэлийн хураамжаас
- Стандартын борлуулалтаас
- Сургалтаас
- Бусад эх үүсвэрээс

Төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг Хорооны хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3. Бодлогын удирдамжаар хангах:

Хорооны хяналтын баг дараах ажлуудыг гүйцэтгэнэ.

- Стратеги, төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх
- Доголдлыг арилгах, тодотгол хийх
- Заавар, зөвлөмжөөр хангах

4.2. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх орчин

Стратеги төлөвлөгөөг Цахилгаан техникийн үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлэн, эцэслэн боловсруулж Монгол Улсын Шадар сайдаар батлуулна.

Стратеги төлөвлөгөө нь урт, дунд, богино хугацааны төсөл, хөтөлбөр, дэд хөтөлбөрүүд, стандартчиллын техникийн хороодын үйл ажиллагааны хөтөлбөр болон задарч хэрэгжинэ.

4.3. Стратегийн хяналт-шинжилгээ үнэлгээ

Хорооны хяналтын баг стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулах, зорилтод төсөл хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан мэдээнд тулгуурлан мэдээлэл цуглуулах, бодлогын дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, үйл ажиллагааг засч чиглүүлэх, тайлагнах үүрэг хүлээнэ.

Стратеги төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж байгаа зорилтод төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг тухайн төсөл, хөтөлбөрийн зорилго, зорилт, арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаанаас хамааран тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу гүйцэтгэнэ.

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шат бүрийн төгсгөлийн жилд тухайн шатанд тавьсан стратеги зорилт, арга хэмжээг бүхэлд нь хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

4.4. Стратеги төлөвлөгөөнд тодотгол хийх

Жил бүрийн эцэст стратеги төлөвлөгөөнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг үндэслэн стратегийн төлөвлөгөөний тооцоолсон үр дүнг бодит үр дүнтэй харьцуулах, гүйцэтгэх ёстой ажил үйлчилгээ төлөвлөсөн цагтаа, төсөвлөсөн хүрээнд биелсэн эсэх, гадаад, дотоод орчны хүчин зүйлийн нөлөөллөөс болж өөрчлөлт орсон эсэх зэргийг нягталж, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, тодотгол хийх саналыг Хорооны хуралд танилцуулж шийдвэрлүүлнэ.